



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Ж.ОД
ТАНАА

2026.02.25 № 02А-2026/213/НА-ОТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ЭМЯ-аас 116,062.9 мянган төгрөгийн, ХӨСҮТ-өөс 510,398.1 мянган төгрөгийн зэрэг нийт 626,461.0 мянган төгрөгийн эм боох материалыг балансаас балансад шилжүүлэн авч аймаг, 17 сумдын 22 эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилж, шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/590 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа эрүүл мэндийн байгууллагын онцлогт нийцэхгүй, тухайн цаг үеэс хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлтүүд мөрдөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус газраас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт нийт 1,166,442.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 1,334,352.4 мянган төгрөгийг олгосон бөгөөд эдгээр нь нийт зардлын **67.5** хувийг уг зардал эзэлж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/218/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn
2026 он	Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Албан шаардлага	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		33,420,616.91	50,074,378.69
33	АВЛАГА		6,731,660.72	13,450,422.50
33300	Татаас, санхүүжилтийн авлага		6,731,660.72	13,450,422.50
35	БАРАА МАТЕРИАЛ		26,688,956.19	36,623,956.19
35100	Түүхий эд материал		15,139,287.19	15,139,287.19
35110	Тусгай зориулалттай материал		9,371,787.19	9,371,787.19
35130	Эм боох материал		5,767,500.00	5,767,500.00
35400	Хангамжийн материал		11,549,669.00	21,484,669.00
35410	Бичиг хэргийн материал		296,149.00	296,149.00
35420	Аж ахуйн материал		11,253,520.00	11,253,520.00
35440	Түлш, шатах тослох материал		0.00	9,935,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		518,175,112.07	453,794,981.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		518,175,112.07	453,794,981.72
39200	Биет хөрөнгө		254,857,912.07	189,524,648.38
39201	Барилга, байгууламж, орон сууц		147,594,083.00	147,594,083.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(46,195,531.17)	(53,573,719.41)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		216,505,880.00	216,505,880.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(213,200,324.60)	(216,505,880.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		430,629,791.73	447,917,311.73
39206	Хуримтлагдсан элэгдэл		(338,429,791.64)	(401,769,293.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		163,753,518.62	163,753,518.62
39208	Хуримтлагдсан элэгдэл		(142,087,830.63)	(146,646,420.84)
39214	Бусад үндсэн хөрөнгө		47,409,960.00	47,409,960.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(11,121,843.24)	(15,160,791.00)
39300	Биет бус хөрөнгө		263,317,200.00	264,270,333.34
39301	Программ хангамж		0.00	986,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		0.00	(32,866.66)
39303	Бусад биет бус хөрөнгө		263,317,200.00	263,317,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		551,595,728.98	503,869,360.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		551,595,728.98	503,869,360.41
51	Засгийн газрын хувь оролцоо		551,595,728.98	503,869,360.41
51100	Засгийн газрын оруулсан капитал		140,566,428.00	140,566,428.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		140,566,428.00	140,566,428.00
51200	Хуримтлагдсан үр дүн		346,929,235.98	299,202,867.41
51210	Өмнөх үеийн үр дүн		501,908,131.62	346,929,235.98
51220	Тайлант үеийн үр дүн		(154,978,895.64)	(47,726,368.57)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		64,100,065.00	64,100,065.00
6	ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		551,595,728.98	503,869,360.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тордуулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		4,407,322,218.20	4,596,806,070.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		543,278,955.12	4,596,806,070.13
120	Нийтлэг татварын бус орлого		543,278,955.12	643,948,527.76

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	235,000.00	17,287,520.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	543,043,955.12	626,661,007.76
122	Тусламжийн орлого	0.00	3,952,857,542.37
1221	Хандив тусламж /дотоод/	0.00	3,952,857,542.37
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.00	3,673,775,440.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	0.00	3,673,775,440.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	279,082,102.37
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	34,002,600.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	63,395,394.40
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	163,491,847.25
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	18,192,260.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,864,043,263.08	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,700,072,186.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,700,072,186.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	163,971,077.08	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,022,150.50	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,618,064.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,330,862.58	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,562,301,113.84	4,644,532,438.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,562,301,113.84	4,644,532,438.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,891,310,758.89	2,053,579,980.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	863,017,904.40	1,041,611,940.87
210101	Үндсэн цалин	502,320,351.00	568,466,193.67
210102	Нэмэгдэл	255,967,956.00	341,945,698.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,515,238.00	53,880,000.00
210104	Урамшуулал	61,214,359.40	77,320,049.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,697,728.49	117,048,729.58
210201	Тэтгэврийн даатгалын зардал	74,281,629.45	79,716,051.99
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	8,552,814.06	9,620,687.32
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,260,937.82	5,547,808.61
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,034,427.04	4,372,734.20
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	16,567,920.12	17,791,447.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,666,685.94	599,813.64
210301	Гэрэл, цахилгаан	1,016,594.94	599,813.64
210302	Түлш, халаалт	3,650,091.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,940,233.00	19,728,071.00
210401	Бичиг хэрэг	6,551,450.00	4,024,025.00
210402	Тээвэр, шатахуун	30,100,803.00	10,152,556.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,536,430.00	3,877,900.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	751,550.00	1,673,590.00
2105	Нормативт зардал	549,385,355.12	626,461,007.76
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	543,197,055.12	626,461,007.76
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,188,300.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,096,622.58	10,767,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	949,500.00	1324100015 9055-0.00
210604	Урсгал засвар	40,147,122.58	10,767,700.00
2107	Томилолт, зочны зардал	26,196,850.00	5,981,100.00
210702	Дотоод албан томилолт	26,196,850.00	5,981,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,528,460.00	9,426,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,424,100.00	6,340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,064,600.00	2,745,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,560.00	71,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,892,200.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	242,780,919.36	221,954,857.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	155,647,112.00	139,301,207.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,533,807.36	82,653,650.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,670,990,354.95	2,590,952,458.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	207,440,353.20
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	207,440,353.20
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.00	207,440,353.20
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.00	207,402,798.21
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	0.00	37,554.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,402,150,050.00	2,383,512,105.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	766,627,152.00	1,242,226,105.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,632,638,798.00	1,140,786,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,884,100.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	268,840,304.95	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	268,840,304.95	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(154,978,895.64)	(47,726,368.57)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(154,978,895.64)	(47,726,368.57)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,952,267,712.08	3,952,857,542.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	3,952,857,542.37
122	Тусламжийн орлого	0.00	3,952,857,542.37
1221	Хандив тусламж /дотоод/	0.00	3,952,857,542.37
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.00	3,673,775,440.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.00	3,673,775,440.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	279,082,102.37

122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	34,002,600.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	63,395,394.40
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	163,491,847.25
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	18,192,260.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,952,267,712.08	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,700,072,186.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,700,072,186.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	252,195,526.08	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,022,150.50	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,618,064.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	123,555,311.58	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,939,702,512.08	3,951,871,542.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,939,702,512.08	3,951,871,542.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,261,980,496.41	1,347,468,661.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	862,943,067.00	1,047,907,849.95
210101	Үндсэн цалин	502,320,351.00	565,406,037.00
210102	Нэмэгдэл	255,967,956.00	353,142,552.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,515,238.00	53,880,000.00
210104	Урамшуулал	61,139,522.00	75,479,260.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,772,565.89	117,048,729.58
210201	Тэтгэврийн даатгалын зардал	74,342,750.85	79,716,051.99
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	8,552,814.06	9,620,687.32
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,242,865.93	5,547,808.61
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,066,214.93	4,372,734.20
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	16,567,920.12	17,791,447.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,666,685.94	599,813.64
210301	Гэрэл, цахилгаан	1,016,594.94	599,813.64
210302	Түлш, халаалт	3,650,091.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,095,753.00	24,579,671.00
210401	Бичиг хэрэг	6,912,250.00	4,040,500.00
210402	Тээвэр, шатахуун	29,030,523.00	14,915,156.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,334,430.00	3,902,925.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	818,550.00	1,721,090.00
2105	Нормативт зардал	5,589,900.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	643,100.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,946,800.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,558,622.58	10,767,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,230,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,241,500.00	0.00
210604	Урсгал засвар	40,087,122.58	10,767,700.00
2107	Томилолт, зочны зардал	25,386,850.00	5,981,100.00
210702	Дотоод албан томилолт	25,386,850.00	5,981,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,588,460.00	10,218,420.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,484,100.00	7,131,660.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,064,600.00	2,745,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,560.00	71,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,892,200.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,378,592.00	130,365,377.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	155,778,592.00	130,365,377.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,677,722,015.67	2,604,402,880.70
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	220,890,775.70
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	220,890,775.70
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.00	220,890,775.70
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.00	207,402,798.21
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	0.00	37,554.99
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.00	13,450,422.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,402,150,050.00	2,383,512,105.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	766,627,152.00	1,242,226,105.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,632,638,798.00	1,140,786,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,884,100.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	275,571,965.67	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	268,840,304.95	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,731,660.72	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,565,200.00	986,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	12,565,200.00	986,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,565,200.00	986,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,565,200.00	986,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,565,200.00	986,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(12,565,200.00)	(986,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	501,908,131.62	706,574,624.62
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	501,908,131.62	706,574,624.62
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(154,978,895.64)	(154,978,895.64)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	346,929,235.98	551,595,728.98

11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	346,929,235.98	551,595,728.98
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	346,929,235.98	551,595,728.98
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(47,726,368.57)	(47,726,368.57)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	299,202,867.41	503,869,360.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,703,059,700.00	3,466,372,641.79	236,687,058.21	93.61
12	Татварын бус орлого	3,703,059,700.00	3,466,372,641.79	236,687,058.21	93.61
120	Нийтлэг татварын бус орлого	4,500,000.00	0.00	4,500,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	4,500,000.00	0.00	4,500,000.00	0.00
122	Тусламжийн орлого	3,698,559,700.00	3,466,372,641.79	232,187,058.21	93.72
122005	Төсвөөс санхүүжих	3,698,559,700.00	3,466,372,641.79	232,187,058.21	93.72
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,703,059,700.00	3,466,372,641.79	236,687,058.21	93.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,703,059,700.00	3,466,372,641.79	236,687,058.21	93.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,201,765,300.00	1,082,860,536.79	118,904,763.21	90.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,008,935,200.00	923,905,478.00	85,029,722.00	91.57
210101	Үндсэн цалин	619,021,300.00	565,406,037.00	53,615,263.00	91.34
210102	Нэмэгдэл	261,863,600.00	229,140,181.00	32,723,419.00	87.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,451,600.00	53,880,000.00	(2,428,400.00)	104.72
210104	Урамшуулал	76,598,700.00	75,479,260.00	1,119,440.00	98.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,432,900.00	113,036,414.15	14,396,485.85	88.70
210201	Тэтгэврийн даатгал	86,640,800.00	76,857,132.56	9,783,667.44	88.71
210202	Тэтгэмжийн даатгал	10,208,900.00	9,292,248.32	916,651.68	91.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,125,100.00	5,249,842.91	(124,742.91)	102.43
210204	Ажилгүйдлийн даатгал	5,091,300.00	4,300,242.90	791,057.10	84.46
210205	Эрүүл мэндийн даатгал	20,366,800.00	17,336,947.46	3,029,852.54	85.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,628,100.00	599,813.64	4,028,286.36	12.96
210301	Гэрэл, цахилгаан	1,166,400.00	599,813.64	566,586.36	51.42
210302	Түлш, халаалт	3,461,700.00	0.00	3,461,700.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,468,700.00	23,097,671.00	11,371,029.00	67.01
210401	Бичиг хэрэг	2,188,300.00	3,950,500.00	(1,762,200.00)	180.53
210402	Тээвэр, шатахуун	24,574,400.00	13,523,156.00	11,051,244.00	55.03
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,446,300.00	3,902,925.00	543,375.00	87.78
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	234,000.00	0.00	234,000.00	0.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,025,700.00	1,721,090.00	1,304,610.00	56.88
2105	Нормативт зардал	909,400.00	0.00	909,400.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	576,400.00	0.00	576,400.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	333,000.00	0.00	333,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,379,900.00	7,267,700.00	1,112,200.00	86.73
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,112,200.00	0.00	1,112,200.00	0.00
210604	Урсгал засвар	7,267,700.00	7,267,700.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	6,950,600.00	5,981,100.00	969,500.00	86.05
210702	Дотоод албан томилолт	6,950,600.00	5,981,100.00	969,500.00	86.05
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,700,900.00	4,072,760.00	628,140.00	86.64
210803	Даатгалын үйлчилгээ	2,745,500.00	2,745,500.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255,800.00	71,260.00	184,540.00	27.86
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	123,500.00	0.00	123,500.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,576,100.00	1,256,000.00	320,100.00	79.69
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,359,600.00	4,899,600.00	460,000.00	91.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,899,600.00	4,899,600.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	460,000.00	0.00	460,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,501,294,400.00	2,383,512,105.00	117,782,295.00	95.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,501,294,400.00	2,383,512,105.00	117,782,295.00	95.29
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,334,352,400.00	1,242,226,105.00	92,126,295.00	93.10
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,166,442,000.00	1,140,786,000.00	25,656,000.00	97.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0.00	0.00	0.00	0.00
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	0.00
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	117	114	3.00	97.44
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35	33	2.00	94.29
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	30	28	2.00	93.33
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34	33	1.00	97.06
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11	0.00	100.00

650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18	17	1.00	94.44
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.00	100.00
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	47	47	0.00	100.00
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	47	47	0.00	100.00

2.6 Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	279,082,102.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	279,082,102.37
122	Тусламжийн орлого	279,082,102.37
1221	Хандив тусламж /дотоод/	279,082,102.37
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	279,082,102.37
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	34,002,600.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,395,394.40
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	163,491,847.25
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,192,260.72
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	265,594,124.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	265,594,124.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	265,594,124.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,002,371.95
210102	Нэмэгдэл	124,002,371.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,012,315.43
210201	Тэтгэврийн даатгал	2,858,919.43
210202	Тэтгэмжийн даатгал	328,439.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	297,965.70
210204	Ажилгүйдлийн даатгал	72,491.30
210205	Эрүүл мэндийн даатгал	454,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,482,000.00
210401	Бичиг хэрэг	90,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,392,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.00
210604	Урсгал засвар	3,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,131,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,131,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,465,777.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,465,777.50
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	13,487,977.49
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(13,487,977.49)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(13,487,977.49)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь “Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж хэнийг ч орхигдуулахгүйгээр хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалж, дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дэвшүүлж, ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон хэрэгжүүлж, ажилласан байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн талаар тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлж, тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах ажлыг орон нутагт удирдан зохион байгуулах,
- Нэгдсэн эмнэлэг, сум, тосгон, өрхийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу эмнэлгүүдийг боловсон хүчин, нэн шаардлагатай байгаа багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эм урвалж бодисоор хангах ажлыг зохион байгуулах,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах, товлолт дархлаажуулалтад хүүхэд бүрийг хамруулан, халдварт болон халдварт бус өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг сайжруулах,
- 0-5 насны хүүхэд, жирэмсэн эхчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, хяналт чанарыг сайжруулж, өвчлөл эндэгдлийг бууруулах,
- Эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэхэд төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагууд болон гаднын төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:


- Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн албаны тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Зөрчлийн тухай хуульд 2025 оны 05 дугаар сарын 30, 07 дугаар сарын 09-нд өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон /2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн/ гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.



Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/590 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан *Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,726.3 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	6,731.7	13,450.4	6,718.7
Бараа материал	26,689.0	36,624.0	9,935.0
Үндсэн хөрөнгө	518,175.1	453,795.0	(64,380.1)
Нийт хөрөнгө	551,595.7	503,869.4	(47,726.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	551,595.7	503,869.4	(47,726.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	551,595.7	503,869.4	(47,726.3)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Авлага данс 13,450.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь өмнөх оны татаас санхүүжилтийн авлагыг барагдуулан, нэмж **13,450.4** мянган төгрөгийн авлага тайлагнагдсанаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,624.0 мянган төгрөг болж 9,935.0 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 90,494.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- ХӨСҮТ, ЭМЯ, Шунхлайпетролиум ХХК зэрэг байгууллагуудаас 626,661.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Үйл ажиллагаанд 707,220.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 453,795.0 мянган төгрөг болж 64,380.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 986.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, ЭМЯ-аас 17,287.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, үндсэн хөрөнгөд 82,653.6 мянган төгрөгийн элэгдэл нэмж байгуулснаас шалтгаалсан байна.

Биет бус хөрөнгө: Тус байгууллага нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 986.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ худалдаж авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт


Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээс 4,501,350.0 мянган төгрөг, зардлыг **4,501,350.0** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 459,912.4 мянган төгрөгөөр бууруулж, нийт **4,041,437.6** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,856.0 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 31,966.3 мянган төгрөгөөр зэрэг нийт 33,822.3 мянган төгрөгөөр **нэмэгдүүлж,**
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 418,255.9 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 50,533.8 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 5,116.0 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 101.4 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 3,880.0 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 9,607.6 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 4,606.8 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 1,633.2 мянган төгрөгөөр зэрэг нийт 493,734.7 мянган төгрөгөөр **бууруулсан** байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 338,377.9 мянган төгрөгөөр бууруулж /цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 54,018.0 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 251,787.5 мянган төгрөгөөр бууруулсан нь голлон нөлөөлсөн байна/ нийт **3,703,059.7** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 3,698,559.7 мянган төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,500.0 мянган төгрөг,



3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,698,559.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 24,784.3 мянган төгрөгөөр дутуу буюу 3,673,775.4 мянган төгрөгийн санхүүжилт авч өөрийн орлогын төлөвлөгөө 4,500.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/383 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын ажиллах журам” өөрчлөгдөж тусгай зөвшөөрлийн орлого төвлөрөхгүй болсноор үндсэн үйл ажиллагааны орлого бүрдээгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **3,466,372.6** мянган төгрөг буюу **93.6** хувьтай тайлагнагдсан нь 207,402.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,196,865.7	1,077,960.9	118,904.8	90.1
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2,501,294.4	2,383,512.1	117,782.3	95.3
3	Хөтөлбөр, төслийн дотоод урсгал	4,899.6	4,899.6	0.0	100.0
	Дүн	3,703,059.7	3,466,372.6	236,687.1	93.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025-2026 онд гүйцэтгэх аудитын ерөнхий чиглэл”-ийн хүрээнд тус байгууллагаас авсан судалгаанд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Байгууллагын даргын 2025 оны 01 дугаар сарын 14-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар өдрийн хоолны хөнгөлөлтийг 10.0 мянган төгрөгөөр тооцож, тайлант онд 53,880.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон,
- Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 359 дугаар тогтоолоор тус газрын дарга Ж.Од хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдож, ажилгүй байсан хугацааны цалин хөлс, НДШ-ийн зардлын нийт **11,033.9** мянган төгрөгийг байгууллагын төсвөөс барагдуулсан байна.
- ЭМЯ, ДЭМБ-аас “Эрүүл мэндийн төвийн ажилтныг чадавхжуулах сургалт”-ын зардалд 11,035.0 мянган төгрөг, “Сэлэнгэ аймаг дахь эрүүл мэндийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалт”-ын зардалд 9,844.0 мянган төгрөг,

Спирт бал бурам ХХК-аас “Жирэмслэхээс өмнөх болон жирэмсэн үеийн тусламж үйлчилгээ” сургалтын зардалд 5,307.6, Премиум нексус ХК-аас “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих арван алхам” сургалтын зардалд 2,128.0 мянган төгрөг зэрэг нийт 28,314.6 мянган төгрөгийн санхүүжилт авч 4 удаагийн хурал, зөвлөгөөн зохион байгуулж ажилласан байна. 324100015 9055436

- Гадаад томилолттой холбоотой зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж, ажил үйлчилгээ гүйцэтгүүлээгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130020401 тоот дансанд нийт 279,082.0 мянган төгрөгийн дараах орлогуудыг төвлөрч, 265,631.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 13,450.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн санхүүгийн дэмжлэгээс албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд 39,635.8 мянган төгрөг,
- ЭМЯ, ХӨСҮТ-өөс дархлаажуулалт болон хүний папилома вирусийн вакциныг товлолд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах ажил болон сургалтын зардалд 162,099.8 мянган төгрөг,
- Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооноос мэргэжлийн туслалцаа үзүүлэх зардалд 18,841.8 мянган төгрөг,
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтээс орон нутгийн вакцины тээврийн зардалд 1,392.0 мянган төгрөг,
- Тендерт оролцогчоос цахим тендерийн баталгаанд 525.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын 2025 оны А/157-А/124 дугаар захирамжаар сургалтын техник хэрэгслийн зардалд 23,759.5 мянган төгрөг,
- Мандал Агро ОНӨААТҮГ, Спирт бал бурам ХХК, Премиум нексус ХК, Баянгол сан зэрэг байгууллагуудаас нийгмийн хариуцлагын хүрээнд сургалтын зардалд 22,021.4 мянган төгрөг,
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас нийгмийн эрүүл мэндийн сургалтын зардалд 4,075.0 мянган төгрөг гэх мэт.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам /Тендер шалгаруулалтын арга/
---	---	------------------	--------------	---

1	Шатахуун, тослох материал нийлүүлэх	25,000.0	23,622.7	Харьцуулалтын арга
	Нийт дүн	25,000.0	23,622.7	

Шатахуун, тослох материал нийлүүлэх тендерт Шунхлайпетролиум ХХК шалгарч гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааг гүйцэтгэсэн байна.

1324100015, 9055436

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 52 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,562,301.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **45,623.0** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн газар нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласнаар бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэсэн,

- *Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлгэ дурсгалын зүйл худалдаж аваагүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамааралтай 31 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалтыг зөрчиж, **7,986.7** мянган төгрөгийн шатахууны нөөц үүсгэсэн зөрчил илэрч албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Нэгдсэн эмнэлэг нь мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллийг хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 431 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 95.0 хувийн биелэлттэй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн нэмэгдлийг илүү олгосон зөрчилд 4,500.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд 10,716.1 мянган төгрөгийн албан шаардлага өгснийг бүрэн биелүүлж, хөрөнгийг

бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт



Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	4,500.2	2	4,500.2	100.0
Албан шаардлага	2	10,716.1	2	10,716.1	100.0
Зөвлөмж	1	-	0	-	0.0
Нийт дүн	5	15,216.3	4	15,216.3	95.0

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газрын төсвийн шууд захирагчийн шийдвэрээр бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Тус газраас тайлант онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 53 албан хаагчид 429,000.0 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон боловч ХХОАТ суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно.” 6.3.1 дэх “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1 дэх “Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **116,989.2** мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Бараа материалын тодруулгад үнэ төлбөргүй хөрөнгийн орлогыг 116,262.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгад тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг 726.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Дээрх алдаанууд нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...”, УСНББОУС 17-ын 59-д “Үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлнэ” дэх заалтууд болон “Үнэлгээ ба хуваарилалт”, Толилуулга” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар **19,020.6** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 3 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 19,020.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 26,602.4 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1.Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **96** нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэх саналыг бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-ын 2 дахь “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, 3 дахь “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 359 дүгээр тогтоолоор хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон тус газрын дарга Ж.Одын 2025 оны 6,7,9,10 дугаар сард ажилгүй байсан хугацааны цалин хөлс, даатгуулагч болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлын нийт **11,033.9** мянган төгрөгийг тус байгууллагаас барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”, Төрийн албаны тухай хуулийн 50

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар зүйлийн 50.1 дэх “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны **төв байгууллага**, эсхүл **шүүх тогтоосон** бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1324100015 9055436

Шийдвэрлэлт: Байгууллагад учруулсан хохирлыг буруутай албан хаагчаар нөхөн төлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны шатахууны зардлын хэмнэлт болох **7,986.7** мянган төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлэлгүйгээр шатахуун нөөцөлж авсан байна. (Тайлант оны шатахууны нийт үлдэгдэл 9,935.0 мянган төгрөг бөгөөд 1 сарын хэрэглээг дунджаар 1,948.3 мянган төгрөгөөр тооцож хасав.)

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь “ ... төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материалыг нөөцлөхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй хөрөнгийн орлогыг зөрүүтэй тайлагнасан	1	116,262.9			1	116,262.9	1	116,262.9		
Элэгдлийн зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	726.3			1	726.3	1	726.3		
Дүн	2	116,989.2			2	116,989.2	2	116,989.2		

/Мянган төгрөгөөр/

Зөвлөмж
1324100015 9055436

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэх болон актлаагүй	1	-			1	-						
Ажилгүй байсан хугацааны цалин, НДШ, ХХОАТ-ын зардлыг тус байгууллагаас барагдуулсан	1	11,033.9			1	11,033.9						
Шатахуун нөөцөлсөн	1	7,986.7			1	7,986.7						
Дүн	3	19,020.6			3	19,020.6						

